



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 26 өдөр

Дугаар А/49

Хэрлэн сум

Авто замын засварын ажлын  
гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах  
ажлын хэсэг байгуулах тухай.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.12, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1, 35.1.3, 42 дугаар зүйлийн 42.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Авто тээврийн уулзвараас цаг уурын уулзвар хүртлэх авто замын засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:	Ц.Бат-Эрдэнэ	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга:	Ш.Ариунболор	Аймгийн Ерөнхий архитектор
Гишүүн:	Х.Баярбаатар	Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн

2.Ажлын хэсгийг удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч (Ц.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатарт)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ